

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо : 2021 оны 1 дүгээр сарын 21-ны өдөр
Тендер шалгаруулалтын нэр: **“ЭКГ 5А №2
ЭКСКАВАТОРЫН ИХ ЗАСВАРЫН АЖИЛД
ШААРДЛАГАТАЙ СЭЛБЭГ, МАТЕРИАЛ”** нийлүүлэх
Тендер шалгаруулалтын дугаар: МРЦМ/202112105

“Монголпросцветмет” ТӨҮГ эрх бүхий тендерт оролцогчдоос **ЭКГ 5А №2 ЭКСКАВАТОРЫН ИХ ЗАСВАРЫН АЖИЛД ШААРДЛАГАТАЙ СЭЛБЭГ, МАТЕРИАЛ** нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэлээр нь **50,000.00 /тавин мянган/** төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **30** хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

Борлуулалтын хэмжээ: **Сүүлийн 2 жил буюу 2019, 2020 оны аль нэгд гүйцэтгэсэн борлуулалтын хэмжээ тендерийн үнийн саналын мөнгөн дүнгийн 100%-иас багагүй байна.**

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: **Сүүлийн 2 жил буюу 2019, 2020 оны аль нэгд тендерт ирүүлсэн үнийн саналын мөнгөн дүнгийн 50 хувиас багагүй байна.**

Үнэлгээнд ашиглах санхүүгийн тайлан ирүүлэх жил: **2019, 2020 он**

Тендерийн хамт **2,200,000.00 (хоёр сая хоёр зуун мянга)** төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг **2021 оны 2 дугаар сарын 26-ны өдрийн 09:00 цагаас өмнө www.tender.gov.mn хаягаар ирүүлэх ба мөн өдрийн 09:10 цагт цахим системээр нээнэ.**

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй, эрхгүй эсэх: **Зөвшөөрнө.**

Дотоодын давуу эрх тооцох эсэх. **Тооцохгүй.**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот, БЗД 22-р хороо, Энхтайвны өргөн чөлөө— 98, 409 тоот өрөө, утас: 450060 + 188